



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 сарын 09 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хог хаягдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

### **1/8 дугаар зүйлийн 8.1.15 дахь заалт:**

“8.1.15. хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, төслийн санал гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих.”

### **2/9 дүгээр зүйлийн 9.3.13 дахь заалт:**

“9.3.13. хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, төслийн санал гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих;”

### **3/41<sup>1</sup> дүгээр зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх**

“41<sup>1</sup>.1. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, төрөлжүүлэн ангилах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлж болно.

41<sup>1</sup>.2. Хог хаягдлын салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар зохицуулна.”

**2 дугаар зүйл.** Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.13 дахь заалтын дугаарыг “9.3.14” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР